



ГОВЬСУМБЭР АЙМАГ  
СУМБЭР СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 70

Сүмбэр сум

Хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт,  
эргэн төлөлтөд хяналт тавих орон тооны бус  
зөвлөл шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.9 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:

Л. Одбаясгалан – ИТХ-ын төлөөлөгч

Гишүүд:

Б. Сувдшүрэн – Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл,  
хоршоо хариуцсан мэргэжилтэн

Төрийн сангийн мэргэжилтэн

Г. Батсүх – Аймгийн ХХААГ-ын хоршоо, жижиг  
Дунд үйлдвэрлэлийн асуудал хариуцсан  
мэргэжилтэн

Д. Өлзийтогтох – Хүүхэд хөгжил ТББ-ын  
төлөөлөл

2. Үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанд тайлагнаж ажиллахыг хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих орон тооны бус зөвлөлийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

